



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/200

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 58.2.17, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын гол бүс нутаг болгон хөгжүүлэх бодлогын хүрээнд хөрш аймгуудын Засаг дарга, тэдгээрийг дагалдах ажлын албаныхантай туршлага солилцох ажил хэргийн уулзалт зохион байгуулсантай холбогдуулан хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.


3. Дээрх зардалд шаардагдах 930000 /есөн зуун гучин мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, зардлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 25 өдрийн 1/200
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хүлээн авалтын төрөл	Нэг хүнд ногдох хоолны үнэ	Нийт хүний тоо	Нийт үнэ
1	Өдрийн хоол	14550	28	407400
2	Оройн хоол	7950	28	222600
3	Бэлэг дурсгалын зүйл	30000	10	300000
Нийт үнэ				930000